

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ  
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№22/561

ШУС, НУС

2021

ХЯТАДЫН ХУВЬСГАЛТ ХЭВЛЭЛҮҮДИЙН ОНЦЛОГ, ТҮҮХЭН АЧ  
ХОЛБОГДОЛ

Ү.Тианбао (Wu Tianbao)\*

\*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн докторант  
(БНХАУ)

**Түлхүүр үгс:** Хятадын сэтгүүл зүй, коммунист нам, ясан бар, мэдээ занги, дармал хэвлэл, төв үзэл

**Д**элхийд цаас үүссэн, үүнийг дагаад ном бичиж, сонин сэтгүүл гаргах болсон нь Хятад Улстай шууд холбоотой түүхэн үйл явдал мөн юм. Анхны ясан бар ашигласнаас хойш мэдээ занги солилцох үйл ажиллагаа 3000 илүү жилийн түүхтэй гэж судлаачид үздэг. Тан гүрний үеийн “ордны сонин”-ы гар бичмэлээс эхлээд өнөөгийн тогтмол хэвлэлийн үе хүртэлхийг тооцохын бол 1200 жилийн үйл явдал болно [1]. Бүр наашлуулж Сүн гүрний үед гарч байсан “бага сонин”-оос эхлэн тооцвол Хятадын дармал хэвлэлийн түүх нь нэгэнт 700-800 жилээр тоологдоно [2]. Орчин үеийн хэвлэл мэдээллийн салбарын үүсэл, хөгжил, үйл ажиллагаа БНХАУ-ын Коммунист намтай шууд холбоотой. Нэг намын төв үзэлт улсын хувьд хэвлэл мэдээллийн байгууллагын дотоод болон гадаад үйл ажиллагаанд нам, засгийн зүгээс тодорхой түвшинд нөлөөллийг үзүүлэх нь тус улсын онцлог билээ.

Хятадын Коммунист намын анхдугаар хурал 1921 оны долоодугаар сарын 23-нд Шанхай хотод нууцаар хуралдсан Тус хуралд Мао Зэдун, Дон Биву зэрэг 13 хүн оролцож, намынхаа хөтөлбөрийг батлан, нэрийг нь “Хятадын коммунист нам” гэж тогтсон байдаг [3]. 1923 онд Хятадын коммунист намын III их хурал болж Хятадын Коммунист нам Хятадын Гоминданы намтай хамтран ажиллах тогтоолыг баталсан юм [4]. Хятадын түүхэнд дээрх хоёр хурлын шийдвэрийг онцгойлон авч үздэг. Зөвхөн түүхэнд төдийгүй хэвлэл мэдээллийн салбарын хөгжлийн эхлэлийг тавих, орчин үеийн Хятадын сэтгүүл зүй, олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдийн цаашдын чиг хандлагыг тодорхойлсон үйл явдал болсон юм. Талууд хамтран өөрсдийн үйл хэргийг сурталчилсан сонин, сэтгүүл гаргах ажлыг эхлүүлжээ. Тухайлбал, Гоминданы намын Зохион байгуулах хэлтсийн бүртгэлийн архивд бичсэнээр Хятадын хойд нутгийн дайнаас өмнө нийт 66 төрлийн сонин, сэтгүүл гарч байсны ихэнхийг коммунистууд

хариуцаж байсан байна. Тэр дундаа Хятадын орчин цагийн тогтмол хэвлэлийн үүсэлд 1925 оны 12 дугаар сарын тавны өдөр Гуанжоу хотод Мао Зэдун үүсгэн байгуулсан “Улс төрийн гарагийн сонин”-ы ач холбогдол их юм [5]. Тухайн үед “Улс төрийн гарагийн сонин” нь Гоминданы намын Төв Хорооны Ухуулах хэлтсийн тогтмол хэвлэл байсан төдийгүй Мао Зэдун тус хэлтсийн орлогч даргаар ажиллаж байв. Тиймээс эхэн үедээ ерөнхий эрхлэгчийн ажлыг хариуцан яваандаа өөр ажилд шилжсэнээр Коммунист намын гишүүн Шенянбин, Жанчиурен, Дэнжүншье нар хариуцан ажиллаж болсон байна. “Улс төрийн гарагийн сонин” 1926 оны зургаадугаар сарыг хүртэл гарсан байна.

“Улс төрийн гарагийн сонин”-д гарч байсан материалуудыг агуулгын хувьд авч үзвэл, ерөнхий зорилго нь баруунтны хувьсгалын эсрэг суртал ухуулга явуулах, Гоминданы болон Коммунист намын хамтын ажиллагааг дэмжин сурталчлах, тус намын хойд нутагт хийж байсан цэрэг дайны үйл ажиллагааг сурвалжлах, Гуанжоуд коммунист үзэл суртлыг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр бичиж нийтэлж байжээ. Жишээлбэл, “Улс төрийн гарагийн сонин”-ы №2 болон №4-т “Хувьсгалт намын бүх гишүүн Бээжингийн баруунтны хурлыг эсэргүүцэгтүн”, “Баруунтны хурлыг эсэргүүцэгчид улс даяар улам нэмэгдэж байна” зэрэг 49 нийтлэл гаргажээ. Мөн анхны дугаараасаа эхлэн “Эсрэг дайралт” гэсэн тусгай булан гаргаж

дээрх бодлогын хүрээнд богино өгүүлэл гаргаж байсан байна. Энэ тусгай буланд Мао Зэдун “Зэрен” (子任) гэсэн нууц нэрээр баруунтны эзэрхэг түрэмгий байдал, цэргийн эрхтэн дархтнуудынх нь хуйвалдаан, шударга бус үйлдлийг илчлэн шүүмжилсэн шог найруулал бичиж байжээ. Тухайн үед Шанхай хотын “Иргэн улсын өдрийн сонин”-д баруунтнуудын үйл ажиллагааг ухуулсан, зөвтгөсөн нийтлэл гарч байсныг Мао Зэдун эсэргүүцэн, эсрэг ухуулга байр суурь бүхий өгүүллүүдээ бичиж байжээ.

**Т**эр үеийн Шанхай хот баруун үзэлтнүүдийн гол үйл ажиллагаа явуулдаг, төв командлал нь байрладаг чухал ач холбогдол бүхий газар байсан байна. Хятадын түүхэнд “Тавдугаар сарын 30-ны хөдөлгөөн” гэж тэмдэглэгдсэн ажилчин ангийн бослого энд болж байсан юм. Ажилчдын цалин хөлсийг олгодоггүй, хөдөлмөрийн мөлжлөг хийдэг гаднын эзэрхэг түрэмгийлэгчид, хөрөнгөтөн болон феодал ангийнхан гэсэн гурван хүчнийг эсэргүүцэн босож, ажил хаялт зарласан ажилчин ангийн тэмцэл байжээ. Энэ үеэр ажил хаялт, эсэргүүцлийн жагсаалыг зогсоохоор баруунтнууд цэрэг илгээснээр мөргөлдөөн болж олон арван хүн амь үрэгдсэн байна. Гэтэл ажил хөдөлмөрөө зохих ёсоор үнэлүүлэхийн төлөө шударга ёсны тэмцэл өрнүүлсэн олон арван ажилчин амиа алдсан эл мөргөлдөөний талаар баруунтнууд олон нийтэд мэдэгдэхийг хүссэнгүй. Нуун дарагдуулж, өөрсдийн сонин хэвлэлд гаргаагүй бай-

на. Тухайн үед Хятадын Коммунист болон Гоминданы намд иймэрхүү гэмт хэргийг олон нийтэд нээлттэй мэдээлэх сонин Шанхайд байсангүй. Тиймээс Хятадын Коммунист намын Төв Хорооноос олон нийтийг үнэн бодит мэдээллээр хангах, намын үйл хэргийг ухуулан таниулах зорилгоор өөрийн хэвлэлийг ажиллуулах шийдвэр гаргасан байна.

**И**нгээд 1925 оны зургаадугаар сарын дөрөвний өдөр "Халуун цус өдрийн сонин"-г (热血日报) Шанхайд үүсгэн байгуулж, гаргах болсон байна [6]. "Халуун цус өдрийн сонин" нь сонин мэдээ, улсын дотоодын чухал мэдээ, дэлхийн чухал мэдээ, онц чухал мэдээ, яриа хэлэлцээний шийтгэл гэсэн булангуудтай, мөн "эрэл хүсэл" гэсэн дагалдах сонин гаргаж түүндээ товч шуурхай мэдээ, уран зохиол, урлагийн тухай нийтэлж байжээ. Гэлээ ч "Халуун цус өдрийн сонин" удаан үргэлжлээгүй байна. Барууны үзэлтнүүдийн шахалт дарамтаар зургаадугаар сарын 27-ны өдрийг хүртэл нийт 24 дугаар л гаргажээ.

"Халуун цус өдрийн сонин"-ы онцлог нь баруунтны хөдөлгөөнийг эсэргүүцсэн хурц дайчин агуулга бүхий нийтлэлүүд юм. Тухайн үед баруунтны хэвлэл гэгдэж байсан "Хойд Хятадын өдрийн сонин", "Эх газрын сонин", "Өнөөдөр сонин" зэргийн нийтлэлийн бодлогыг эсэргүүцэн тэдний гаргасан мэдээ, нийтлэлийн эсрэг няцаалт өгөх, Хятадын Коммунист намын үзэл баримтлалыг ухуулан таниулах зорилго бүхий өгүүллүүдийг гаргаж байжээ. "Ха-

луун цус өдрийн сонин" –ы бас нэг онцлог нь улс төрийн шинжтэй мэдээг чухалчилахаас гадна хэл найруулгын хувьд хялбар, ойлгомжтой, олон нийтэд хандсан хэв шинжтэй байсан байна. Тиймээс хэвлэгдэн тараагдсан үеэсээ эхлэн уншигчдын анхаарлыг татаж, гурван түм гаруй хувь хэвлэгдэн, өдөр бүр уншигчдын захидал, уулзалтанд дарагдаж, зөвхөн нэг өдөр уулзах уншигчдыг хүлээн авсан тоо 100 гарч байжээ. "Халуун цус өдрийн сонин" нь тухайн үед зэрэгцэн гарч байсан "Газарч", "Хятадын залуучууд" зэрэг бусад хэвлэлийг бодвол илүү дайчин шуурхай шинжтэй байж, ажилчдын ажил хаялтыг зохион байгуулахад голлох удирдлагын үүргийг гүйцэтгэсэн байна.

Сонин хэвлэлийн үүрэг, ач холбогдол, олон нийтэд үзүүлэх нөлөөллийн ач холбогдлыг ухаж ойлгосон Хятадын Коммунист болон Гоминданы намынхан ардчилсан хувьсгалыг тууштай явуулж, олон нийтийн ухуулан сэнхрүүлэхийн тулд хэвлэл мэдээлэл хариуцсан багийг намын удирдлагын түвшинд байгуулсан байна. Мэргэжлийн сэтгүүлчдээс бүрдсэн хэвлэлийн баг, тухайн нийгмийн дэвшилтэт бүлгэмүүдийн хамтын үйл ажиллагааны үрээр сонин, сэтгүүл хэвлэн нийтлэх үйл ажиллагаа эрчимтэй өрнөж эхэлжээ.

Хятадын Коммунист нэм 1922 оны долоодугаар сард Шанхай хотод Бүх Улсын Төлөөлөгчдийн Хоёрдугаар их хурлаа хуралдуулж, намын дээд болон доод хөтөлбөрийг баталсан байдаг. Энэ их хурлаар

Хятадын Коммунист Намын Төв Хорооны сонин болох “Газарч” (向导) долоо хоног тутмын сэтгүүлийг үүсгэн байгуулах шийдвэр гаргажээ. Энэ бол Хятадын Коммунист Намын Төв Хорооноос эрхлэн гаргасан хамгийн анхны улс төрийн хэвлэл юм [7]. 1922 оны есдүгээр сарын 13-нд Шанхай хотод анхны дугаар нь хэвлэгдэж, 1927 оны долоодугаар сарын 18-нд хаагдсан байна. Нийт 201 дугаар хэвлэгдэн Хятадын Гоминдан, Коммунист намын нэгдсэн фронтод үүссэн нөхцөл байдлаас шалтгаалан хаагджээ.

**Х**ятадын Коммунист Залуучуудын Эвлэл мөн өөрийн тогтмол хэвлэлтэй байсан юм. Эвлэлийн төв хороо 1923 оны 10 дугаар сарын 20-ны өдөр “Хятадын залуучууд” (中国青年) сэтгүүлийн анхны дугаарыг Шанхайд эрхлэн гаргасан байна. Нийтдээ таван жилийн турш тасралтгүй үйл ажиллагаа явуулж 1927 оны 10 дугаар сард хаагджээ.

Хятадын ард түмэн сонин хэвлэлийн ач холбогдол, нөлөөг сайтар ойлгож ажилчин, тариачин, худалдаачин, сурагч, цэрэг зэрэг олон нийтийн бүлгүүд өөрсдийн салбарын сониноо үүсгэн байгуулах болсон байна. Тэдгээр хэвлэлүүд нь эзэрхийлэн түрэмгийлэгчид, феодал хамжлагат ёсыг эсэргүүцэж, бүх нийтийн тэгш эрх, иргэний хувьсгалыг дэмжин, Хятадын Коммунист намын үйл хэргийг ухуулан сурталчлах үүргийг гүйцэтгэж байжээ.

Дээрх тогтмол хэвлэлүүдээс гадна Хятадын Коммунист намаас байгуулагдсаны дараах эхний жи-

лүүдэд эрхлэн гаргаж байсан нэлээн олон хувьсгалт хэвлэлүүд байдаг. Үүнд “Хөдөлмөр гарагийн сэтгүүл”, “Ажилчны гарагийн сэтгүүл”, “Шаньдуны хөдөлмөр гарагийн сэтгүүл” зэрэг ажилчин ангийн хувьсгал тэмцлийг дэмжсэн, ухуулгын хэв шинжтэй сонин сэтгүүлийг эрхлэн гаргаж байжээ. Тэр дундаа “Хөдөлмөр гарагийн сэтгүүл” бол ажилчин ангид зориулагдсан, Хятадын бүх нутаг дэвсгэрээр тараагдаж байсан анхны сонин юм.

Тухайн үед Гоминданы нам болон Коммунист нам хамтран эв санаагаа нэгтгэсэн нь Хятадын иргэний хувьсгалд түлхэц болсон төдийгүй орчин цагийн сэтгүүл зүйн үйл ажиллагаа, ОНМХ-ийн хөгжилд онцгой ач холбогдол үзүүлжээ.

Энэ хугацаанд ажилчин, тариачдад зориулсан сонин сэтгүүл 20 шахаж, коммунист залуучуудын эвлэл, оюутны холбоо, цэрэг арми, эмэгтэйчүүдийн сонин сэтгүүл олноор гарах болсон байна. Үүнээс “Залуу ажилчин”, “Багачуудын хошууч”, “Хятадын цэргийн хүмүүс”, “Бүсгүйчүүдийн дуун”, “Бүсгүйчүүдийн гарагийн сэтгүүл”, “Бүсгүйчүүдийн өдрийн сонин” зэрэг хэвлэлүүд эрэлт ихтэй байжээ.

Энд нэг зүйлийг онцгойлон дурдахгүй байж болохгүй. Тухайн цаг үед Хятадад аж төрж байсан монголчууд бие даан сонин сэтгүүл эрхлэн гаргаж байв. “Монгол хошуудад тархаах арван өдрийн дармал” (蒙旗旬, “Монголын тариачин”(蒙古农民), “Өвөр Монголын ардын сэтгүүл” (内蒙国民旬刊) зэрэг юм.

Эдгээр хэвлэлүүдийн нийтлэлийн бодлого нь эзэрхэн түрэмгийлэгчид, феодал ёс, цэргийн эрхтэний ноёрхлыг эсэргүүцсэн сэдвүүдийг гол агуулгаа болгож байжээ.

“Монгол хошууд тархаах арван өдрийн дармал” сэтгүүл 1924 оны дөрөвдүгээр сард Мүгдэнд анх хэвлэгдэж, арван зургаан зүсмийн цаасны сэтгүүл буюу хэмжээ нь 17см\*27см-аар гарсан байна. Хуудасны тоо харилцан адилгүй, тогтмол бус, монгол хятад хэлээр, хорголжин бараар дармалдаж гаргажээ. Тус сэтгүүлийг Мүгдэн дэх Зүүн хойтын Засгийн хэргийг шийтгэх зөвлөлийн Монгол хошуудын хэргийг шийтгэх газар эрхэлж, Хэшингэ монгол хэлээр найруулан орчуулж, Зүүн Монголын бичгийн хороонд хэвлэж байсан байна. Нийт долоон жил хэвлэгдэж 1931 онд хаагджээ.

“**М**онголын тариачин” сэтгүүлийг Бээжин хот дахь Монгол-Төвдийн сургуулийн Хөх хотын Түмд нутгаас гаралтай хэсэг оюутан эрхлэн гаргаж байсан байна. 1925 оны дөрөвдүгээр сарын 28-нд өдөр Бээжин хотод анхны дугаар нь гарч, хагас сар тутамд хэвлэгдэж байжээ. Монголчуудын хувьсгалт үйл ажиллагааг удирдаж байсан хувьсгалч Юнзе (Улаанхүү) “Монгол тариачин” сэтгүүлийг ерөнхий эрхлэгчээр ажиллаж байсан юм. “Монголын тариачин” сэтгүүл нь Хятадад амьдарч буй, Гоминданы болон Коммунист намын нэгдмэл фронтыг дэмжигч монголчуудын эрхлэн гаргасан хамгийн анхны хувьсгалт сонин билээ. Улс төрийн шүүмж, ард иргэ-

дийн аж байдал, хүнд хэцүү нөхцөл, шинэ дэвшилтэт санал бодол, монголын иргэншил, дэлхийн монголчуудын амьдрал, тухайн үеийн Өвөр Монголын бодит байдал зэргийн талаар нийтэлдэг, эзэрхэн түрэмгийлэгчид, феодал ёс, цэргийн эрхтэний ноёрхлыг эсэргүүцсэн Хятадын коммунист намын үндэсний хувьсгалын хөтөлбөрийг сурталчлах, монгол малчид, тариачдын ангийн үзэл ухамсрыг дээшлүүлэх зэрэг гол агуулга зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулж байжээ. “Өвөр Монголын ардын сэтгүүл”-ийг Өвөр Монголын Ардын Хувьсгалт Намын Төв Хорооноос эрхлэн 1925 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр Чуулалт хаалгад хэвлэн гаргажээ. “Энэ сэтгүүлийг Өвөр Монголын Ардын Хувьсгалт Намын Төв Хорооноос арван хоногт нэг удаа хэвлэн гаргаж, олон ардын тусад зориул-мой” [8] гэж эхний нүүрэндээ бичиж байжээ. Дундад Иргэн Улсын 14 дүгээр оны 11 сарын 16-ны (Европ тооллын 1925 он) өдөр хэвлүүлсэн эхний дугаарт “Олон нийтэд тус сэтгүүл гаргасны учрыг илтгэх нь....Сэтгүүл хэмээгч хүний явдлын чухал зүйл бөгөөд дэлхий дахиныг сайжруулж чадмой..... Одоо бид нар чухам өөрийн монголын сэтгүүл сониныг гаргаж, *нэгэн дор*: олон монгол ардын аж амьдрал ашиг тусыг хамгаалан бадруулах; *хоёрт*: олон түмний төөрсөн бодлыг алдраан, чухам үнэн явдлын сонсгол ариун мөрийг илтгэх; *гурав дор*: ард түмний эрх чөлөө эрдэм соёлыг бадруулах зэргийг гол болгосон болой” [9] гэж сэтгүүл урагшлах

хөтчөө өгүүлэн тодорхойлсон юм. “Өвөр Монголын ардын сэтгүүл” бол Өвөр Монголын Ардын Хувьсгалт Намын үүсгэн байгуулсан, төрийн намын анхны байгууллагын сонин байж, мөн улс төрийн өгүүлэл шүүмжийг гол болгосон ерөнхийлсөн чанартай сэтгүүл юм. Сэтгүүл засаг төрийн хэсэг, нам бүлгийн хэсэг, яруу найргийн хэсэг, сэргээн дуудах уриа, чухал сонсголын хэсэг зэрэг булангуудтай. Өвөр Монголын Ардын Хувьсгалт Намын хөтөлбөр зорилт, төрийн бодлогыг сурталчлан, өгүүлэл шүүмжээр гол болгон, шүүмж мэдээ нийтэлж байжээ.

**Д**ээрх гурван сонин сэтгүүл нь Гоминдан, Коммунист намын хамтран ажилласан он жилүүдэд гарч байсан монгол хэл дээрх хэвлэлүүд бөгөөд монгол хэлний уншигчдад шинэ үзэл санаа хүргэж, Хятадад аж төрж байсан монголчуудын иргэний хувьсгалын оролцоог нэмэгдүүлсэн чухал ач хол-богдолтой байсныг судалгааны бүтээлүүдэд дурдсан байдаг юм.

Мөн Гоминданы болон Коммунист намын хамтран ажилласан үед нийт Хятадын хэмжээнд 155 мэдээллийн агентлаг үйл ажиллагаа явуулж байжээ [10]. Ихэнх нь харьцангуй багшаархан агентлагууд байж, тэднээсээ харьцангуй томд Улсын мэдээ мэдээллийн хороо (国闻通讯社), Шэнши мэдээллийн хороо

(申时通讯社), Төвийн мэдээллийн хороо (中央通讯社) тооцогдож байв.

Эдгээр мэдээллийн агентлагууд нь Хятад улсыг өрнөтэй холбосон гүүр болж байв. Дэвшилтэт үзэл

санааг авчирч дэлгэрүүлээд зогсохгүй, иргэдийн ахуй амьдралд ч нөлөөлж байжээ. Тухайлбал, Хятадын үндэсний хувцас олон талаар баяжиж, европ хоолны газрууд олноор нээгдэн, үйлчлүүлэгчид ч ихтэй байдаг байж. Мөн Хятадын олон хотод Европ маягийн барилга төдийгүй Хятад Европ хийцийг хавсарсан төрөл бүрийн хээнцэр орон сууцууд баригдах болжээ.

1922 онд Хятадын баян худалдаачны дэмжлэгтэйгээр Америкийн сэтгүүлч Усван Шанхай хотод Радио хороо үүсгэн байгуулсан байдаг. 1923 оноос эхлэн “Сонин мэдээ”, “Зар мэдээ”, “Утга урлаг” зэрэг сэдвийн хүрээнд нэвтрүүлэг хийн цацах болжээ. “Үдэш бүр сонин мэдээ түгээж, зугаа цэнгэл, хошин шог, наадмын нэвтрүүлэг хийдэг. Дөрөв тав хоног туршин нэвтрүүлсэнд үр нөлөө нь маш сайн байна” [11] гэж “Иргэн улсын өдрийн сонин”-д бичиж байжээ. 1923 оны нэгдүгээр сарын 27-ны өдөр тус радиогоор Сун Ятсены “Найрамдлаар нэгтгэх тунхаг”-ыг бүх агуулгаар нь нэвтрүүлсэн байдаг. Хөрөнгөтөн ангийнхны дунд хувьсгалт үзэл санаа үүсэн бэхжихэд онцгой үүрэг гүйцэтгэсэн гэж Хятадын сэтгүүл зүй судлаачид үздэг. Тус судалгааны өгүүлэлд дурдагдсан тогтмол хэвлэлүүд, радио нь Хятадын хувьсгалын үеийн ОНМХ-ийн гол төлөөллүүд гэж тооцогддог юм.

Хятадын таван сарын дөрөвний Шинэ соёлын хөдөлгөөний үеэс эхлэн Бээжингийн их сургуульд сэтгүүл зүйн мэргэжлийн сургалт явуулах болсон. Сонин хэвлэл эрх-

лэн гаргаж байсан өмнөх туршлага, шинэ үеийн мэргэжлийн боловсрол хамтран орчин үеийн Хятадын сэтгүүл зүйн хөгжлийн эхлэлийг дээд боловсролын академик түвшинд гаргаж ирж чадсан билээ.

### Эшлэл

- 1.高建国,世界上最早的报纸—我国唐朝的“邸报”,1983,(03).
2. 知非,宋朝的邸报和小报,新闻业务 . 1962,(06).
- 3.课程教材研究所,历史必修,内蒙古教育出版社翻译出版,2019, 107 页.
- 4.课程教材研究所,历史必修,内蒙古教育出版社翻译出版,2019, 109 页.
- 5.余玉,毛泽东著《<政治周报>发刊理由》,新闻界. 2014,(01).
- 6.周文娟,《热血日报》办刊的历史经验与当代价值,新闻爱好者. 2019,(05).
- 7.钱承军著“建国前中国共产党报刊研究”,中国文联出版社,2009, 第 40 页.
- 8.特古斯朝克图.蒙古文报刊简史,呼和浩特,内蒙古大学出版社,1999, 252 页.
- 9.特古斯朝克图.蒙古文报刊简史,呼和浩特,内蒙古大学出版社,1999, 257 页.
- 10.钱承军著,建国前中国共产党报刊研究·中国文联出版社,2009,89 页.
11. 复旦大学新闻系新闻史研究室. 简明中国新闻史,福州市,福建人民出版. 1986 , 231 页.

### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. 课程教材研究所,历史必修,内蒙古教育出版社翻译出版,2019.
2. 特古斯朝克图.蒙古文报刊简史,呼和浩特,内蒙古大学出版社,1999.
3. 复旦大学新闻系新闻史研究室. 简明中国新闻史,福州市,福建人民出版社,1986.
4. 钱承军著,建国前中国共产党报刊研究·中国文联出版社,2009.
5. 高建国,世界上最早的报纸—我国唐朝的“邸报”,1983,(03).
6. 谷小水,再论第一次国共合作的起源,中山大学学报(社会科学版). 2021,(04).
7. 郑香妞,国共两党合作的历史经验教训,经济研究导刊. 2011,(32).
8. 周文娟,《热血日报》办刊的历史经验与当代价值,新闻爱好者. 2019,(05).
9. 余玉,毛泽东著《<政治周报>发刊理由》,新闻界. 2014,(01).

### Summary

In the long history of China's media development, it has a far-reaching impact on the authorities and political parties. During the first cooperation between the Communist Party of China and Kuomintang, the role of the media in political parties was brought into full play. Among them, Mongolian newspapers and periodicals also have their own historical value.